



**БУЛГАН АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

63086 Булган аймаг, Булган сум, Булган баг,
Утас: (+976) 7034-2360, Факс: 7034-2360,
Цахим хаяг: Bulgan_tsag_uur@yahoo.com

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ "АЖЛЫН ХЭСЭГ"-Т

2026.02.28

№ 04/30

Танай _____-ны № _____ Т

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан, орон нутагт ажиллаж буй салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор дараах саналыг хүргүүлж байна.

Хуулийн төслийн 33.3.2 дахь заалтад "сум, багийн нутаг дэвсгэрт байрших станцын ажилтанд..." гэж заасан нь аймгийн төвийн ус цаг уурын байгууллагын албан хаагчдыг орхигдуулсан байна. Үүнийг дараах үндэслэлээр өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

1. Салбар хоорондын тэгш байдал: Төрийн албаны тухай хууль болон бусад салбарын хуулиудад (Боловсрол, Эрүүл мэнд, Соёл урлаг) орон нутгийн тэтгэмжийг аймаг, сум, баг гэж ялгаварлалгүйгээр олгодог. Тухайлбал, аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчны газрын мэргэжилтнүүд аймагт ажилладаг хэдий ч энэхүү тэтгэмжид бүрэн хамрагддаг. Ижил чиг үүрэг бүхий Ус цаг уурын салбарт ийм зааг тогтоох нь төрийн албан хаагчдын эрх зүйн байдлыг дордуулж байна.

2. Мэргэжил арга зүйн зангилаа ба хүний нөөц: Аймгийн төвийн албан хаагчид нь сум, багийн станцуудыг мэргэжил арга зүйгээр хангах, мэдээллийг нэгтгэн боловсруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг салбарын гол цөм юм. Сум, багийн ажилтнууд "Орон нутгийн нэмэгдэл" болгож аймгийн төвийнхөөс 20 хувиар илүү цалин авч байгаа дээр нэмэгдэн 5 болон 3 жилийн тэтгэмжээс аймгийн төвийнхнийг хасах нь мэргэшсэн боловсон хүчин төвөөс дайжих, ажиллах сонирхолгүй болох үндсэн шалтгаан болно.

3. Нийгмийн баталгаа: Аймгийн төвд ажиллаж буй албан хаагчид ч мөн адил орон нутгийн хүнд нөхцөл, алслагдмал байдалд үүрэг гүйцэтгэж байгаа тул тэднийг нийгмийн баталгааны гадна үлдээх нь шударга ёсны зарчимд нийцэхгүй.

Санал болгож буй найруулга:

"33.3.2. Орон нутгийн УЦҮОШТ-ийн албан хаагчдад эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгох;"


Дээрх саналыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаж, салбарын ажилтнуудын нийгмийн баталгааг ижил түвшинд хангаж өгөхийг хүсье.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАНДИНБАТ



Төвийн даргын 2026 оны 02 дугаар
сарын 23-ны өдрийн 01/30 тоот
албан бичгийн хавсралт



ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

Хуулийн төслийн заалт (Одоогийн)	Санал болгож буй найруулга (Шинэчилсэн)	Үндэслэл, тайлбар
33.3.2. сум, багийн нутаг дэвсгэрт байрших станцын ажилтанд эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгох;	33.3.2. Орон нутгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчдад эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгох;	Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, байгаль орчны салбарын адил төстэй зохицуулалтыг зохицуулах, хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг ижил түвшинд хангах.